



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016.11.09 № 01/168

БАЯНЖАРГАЛАН СУМЫН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Б.ЦЭЦЭГЖАРГАЛ ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Баянжаргалан сумын Цэцэрлэгийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар нийт 48,354,874.00 /Дөчин найман сая гурван зуун тавин дөрвөн мянга найман зуун далан дөрөв/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ.

1. Аудит хийх явцад 17,912,162.00 төгрөгийн хүнсний материалыг цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг нормоор бодоогүй, хяналтгүй зарцуулж зардалд тайлагнасан байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад /1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг/, Төсвийн тухай хуулийн 41.2.3-т /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах/ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Нийт 30,442,712.00 төгрөгийн цалин олгохдоо ажилчдын картаар олгох цалингийн жагсаалт хийгээгүй, нэрийн дансыг бичилгүй шилжүүлж анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 14.3.1-т /анхан шатны баримт бүрдүүлэх/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1000000712

1. Холбогдох стандарт, журмын дагуу хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг нормоор бодож зарцуулалтанд хяналт тавьж хэвших.
2. Санхүүгийн анхан шатны баримтыг үнэн, зөв бүрдүүлж баримтжуулж хэвших
3. Цалин олгохдоо ажилчдын картаар олгох, цалингийн жагсаалт хийж нэрийн дансаар олгон баримтжуулж байх
4. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Баянжаргалан сумын Цэцэрлэгийн эрхлэгч /Б.Цэцэгжаргал/, нягтлан бодогч /О.Ууганбаатар/ нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:

ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ



Б.ЦЭЦЭГЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ

О.УУГАНБААТАР

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.